



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6,767,165.00 (зургаан сая долоон зуун жаран долоон мянга нэг зуун жаран таван) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Цэдэнбалжир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4.Хөрөнгийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137005808
21-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 08 дугаар сарын 08 ны өдрийн
398 дугаар тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Автомашинны нэр, төрөл, марк, улсын болон арлын дугаар	Үйлдвэрлэсэн огноо	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Дуудлага худалдаагаар худалдах доод үнэ (төгрөг)
1	Жижиг оврын трактор /пад/	2011.04.26	2001	1,910,000.00	1,200,000.00
2	Жижиг трактор, ЮМЗ-6	2000.10.29	2000	4,857,165.00	1,500,000.00
	НИЙТ ДҮН			6,767,165.00 (зургаан сая долоон зуун жаран долоон мянга нэг зуун жаран таван төгрөг)	2,700,000.00 (хоёр сая долоон зуун мянган төгрөг)